



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/133/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203 Цахим хаяг:
bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 7058-4204 Цахим хаяг:
tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ө.Сийлэгмаа Утас: 7000-3775

Цахим хаяг:khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал..	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	13
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19

Аудитын гэрчилгээ

БАЯНТҮМЭН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА. У.УРТНАСАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Аудитын тайлан

2.1. Оршил

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга У.Уртнасан Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 26-нээс 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 ны 02 дугаар сарын 27 -ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймгийн Төрийн аудитын газрын захиалгаар "Хаан консалтинг аудит" ХХК-ийн аудитор Ө.Сийлэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн

аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “ Аймгийн Эрүүл мэндийн салбарын хэмжээнд удирдлагын болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бодлогыг оновчтой хэрэгжүүлэн, үйлчлүүлэгчдэд ээлтэй тэгш хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг хүргэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Дорнод аймгийн Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хөгжүүлэх замаар тэдний амьдралын чанарыг сайжруулж дундаж наслалтыг уртасгахад оршино.”

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Ахplorer программ хангамж ашигладаг байна.

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 39 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн зардлын үзүүлэлтийг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 341,082.8 мянган төгрөгөөс тооцон 6,821.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 6,821.6 мянган төгрөгөөр тооцсон төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн чухал үзүүлэлт болох зардлаас материаллаг байдлын түвшинг тооцсонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 119.0 мянган төгрөгөөр буюу 50 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	00.00	-
Авлага	00.00	00.00	-
Урьдчилгаа	00.00	00.00	-
Бараа материал	18,479.5	19,170.5	691,0
Үндсэн хөрөнгө	100,613.7	219,014.8	118,401.0
Хуримтлагдсан элэгдэл	(39,372.0)	(58,180.8)	(18,808.8)
Нийт хөрөнгө	119,093.3	238,185.3	119,092.0
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	119,093.3	238,185.2	119,091.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	119,093.3	238,185.2	119,091.9

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь 691,0 мянган төрөгийн үнэ төлбөргүй эм, эмнэлгийн хэрэгсэл орлогодсоноос шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 118,401,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд хөрөнгө оруулалт хийснээс шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгөөр 81,573.3 мянган төгрөгийн ариун цэврийн байгууламж, Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр халаалтын зуухны засварт 20,532.9 мянган төгрөгийн засвар хийж, халаалтын тогоо 15,082.3 мянган төгрөгөөр, машин тоог төхөөрөмж 11,596.1 мянган төгрөгөөр, төсвийн урсгал зардлаас 34,362.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж тус тус худалдан авсан дүнгээр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 238,185.2 мянган төгрөг болж 119,091.9 мянган төгрөгөөр өссөн нь дээрх бараа материалын болон үндсэн хөрөнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 342,754,8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлгээр 301,785.3, нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 24,146.9, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 24,146.9 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 324,973.1 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилтээс 17,781.7 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан буюу 1,998.2 мянган төгрөгийн дансны үлдэгдэл төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас ахмадын болон хүүхдийн сувиллын зардалд 1,050.0 мянган төгрөг, Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 2,000.0 мянган төгрөгийг түргэн тусламжийн автомашины засварын зардалд олгосон санхүүжилт нь нэмэлт дансны орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Эмийн зардалд 54.0 мянган төгрөг, хоолны зардалд 996.0 мянган төгрөг, урсгал засварт 2,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 39 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 39 эрсдэл тодорхойлж нийт 39 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 31,105.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3,404.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 19,847.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,853.4 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 27,347.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,854.4 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. 2019 онд эмийн тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн бөгөөд 2,234.8 мянган төгрөгийн илүү үнээр эм нийлүүлсэн нь ТБОНӨБҮХАТухай хуулийн 41.1.2-т заасан " хуулийн 40.4-т зааснаас бусад бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно" гэсэн заалыг зөрчсөн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв .

2. Тайлант хугацаанд хийсэн 17,613.0 мянган төгрөгийн худалдан авалтын Е-баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг мөрдөх анхан шатны баримтын загвар, бүрдүүлэх аргачлалыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5 дахь заалт, Монгол Улсын стандарт MNS 6529:2015 "татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах" гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

Аудитаар илэрсэн 7,499.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Бараа материалыг жинхэнэ нэрээр нь буюу нэр төрлөөр нь бүртгэлд бүртгэж байх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянтүмэн сумын эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6,611.20 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлснээс албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Нийт 1 зөвлөмж өгснөөс хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянтүмэн сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зарцуулалтыг жоолооны тооцооны хуудаснаас явсан зам км, зарцуулсан шатахууныг нормоор зарцуулсан эсэхийг тооцоолж шалгаж үзэхэд 238,5 төгрөгийн шатахууныг нормоос илүү зарцуулсан байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Норм, нормативийг дагаж мөрдөх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

2. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

НБББББ-ийн 5-р зүйлд Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тооцох тухай, 4-р зүйлд үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо 2014 онд хүчингүй болсон ЗГ-ын 2005 оны 233-р тогтоолийг дагаж мөрдөх тухай заасан байна

2.2. Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлд алдаа гарах.

2.3. Өгсөн зөвлөмж:

НБББББичигт тодотгол хийж шинэчлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

3. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн программ нь орон нутгийн өмчийн бүртгэлийн цахим системд холбогддоггүй ба хөрөнгийн бүртгэлийн маягт гарахгүй байна.

3.2. Эрсдэл:

Бусад байгууллагуудад өгөх мэдээллийг боловсруулахгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программд шинэчлэлт хийлгэх.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

4. Дотоод хяналттай холбоотой асуудал :

4.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн тайланд биет бус хөрөнгийн үлдэгдэлд хяналтын тооллого хийж үзэхэд 770,0 мянган төгрөгийн өртөг бүхий санхүүгийн программ хангамж бүртгэлгүй байв.

4.2. Эрсдэл:

Хөрөнгийн элэгдэл тайлант хугацааны зардалд тооцогдохгүй байх, үйл ажиллагааны зардал буруу илэрхийлэгдэх.

4.3. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг данс бүртгэлд бүртгэх.

4.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

5.Зардлын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Ерөнхий журналын бичилтүүдийг бүхэлд нь шалгаж үзсэнээс алдаатай байх магадлалтай 40 ажил гүйлгээний журналын бичилтыг шалгахад 33 гүйлгээ буюу 6,490.6 мянган төгрөгийн гүйлгээ тооцооны дансаар дамжуулахгүй шууд зардлын дансанд бичсэн байна.

5.2. Эрсдэл:

Тайлан буруу илэрхийлэгдэх, хөрөнгө шамшигдах.

5.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 26.1."Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан дансны зааварыг мөрдөж ажиллах.

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

5 Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

6.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлийн хугацаа дууссан, ашиглагдахгүй байгаа 1 программ хангамжийг данс бүртгэлээс хасаагүй байна.

6.2. Эрсдэл:

Дүрэм, журмыг хэрэгжүүлээгүй бөгөөд, үр өгөөжгүй хөрөнгө бүртгэлд тусгасан байна.

6.3. Өгсөн зөвлөмж:

Журмын дагуу данс бүртгэлээс хасах.

6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг дагаж мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

СТ-1А

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,479,585.22	19,170,475.22
БАРАА МАТЕРИАЛ	18,479,585.22	19,170,475.22
Түүхий эд материал	4,488,049.20	4,488,049.20
Тусгай зориулалттай материал	4,417,478.50	4,417,478.50
Эм боох материал	70,570.70	70,570.70
Хангамжийн материал	13,901,536.02	14,592,426.02
Аж ахуйн материал	10,271,860.90	10,897,750.90
Түлш, шатах тослох материал	2,520.12	2,520.12
Бусад хангамжийн материал	3,627,155.00	3,692,155.00
Мал амьтад	90,000.00	90,000.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	100,613,740.89	219,014,772.21
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	100,613,740.89	219,014,772.21
Биет хөрөнгө	96,697,740.89	215,098,772.21
Барилга, байгууламж, орон сууц	17,890,681.64	38,423,580.64
Хуримтлагдсан элэгдэл	-	(1,104,682.92)
Авто-тээврийн хэрэгсэл	36,338,902.00	36,338,902.00
Хуримтлагдсан элэгдэл	(11,558,540.36)	(16,514,612.72)
Машин тоног төхөөрөмж (компьютер)	42,852,900.30	62,874,185.30
Хуримтлагдсан элэгдэл	(15,983,709.92)	(21,589,648.29)
Тавилга, аж ахуйн эд хогшил	38,633,120.00	38,633,120.00
Хуримтлагдсан элэгдэл	(11,475,612.77)	(16,606,705.16)
Бусад үндсэн хөрөнгө	-	96,655,612.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(2,010,978.64)
Биет бус хөрөнгө	3,916,000.00	3,916,000.00
Програм хангамж	354,181.00	354,181.00
Хуримтлагдсан элэгдэл	(354,181.00)	(354,181.00)
Бусад биет бус хөрөнгө	3,916,000.00	3,916,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	119,093,326.11	238,185,247.43
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	119,093,326.11	238,185,247.43
Засгийн газрын хувь оролцоо	119,093,326.11	238,185,247.43
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	114,329,046.64	114,329,046.64
Өмч: - төрийн	114,329,046.64	114,329,046.64
Хуримтлагдсан үр дүн	(58,554,119.22)	60,537,802.10
Өмнөх үеийн үр дүн	(58,554,119.22)	(58,554,119.22)
Тайлант үеийн үр дүн	-	119,091,921.32
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	63,318,398.69	63,318,398.69
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	119,093,326.11	238,185,247.43

4.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	269,882,720.00	463,578,940.29
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,813,260.00	141,921,040.29
Нийтлэг татварын бус орлого	5,813,260.00	133,557,650.29
Төсөв байгууллагын өөрийн орлого	5,813,260.00	133,557,650.29
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,813,260.00	133,557,650.29
Тусламжийн орлого	-	8,363,390.00
Хандив тусламж /дотоод/	-	8,363,390.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,069,460.00	321,657,900.00
Улсын төвлөрсөн төсвөөс	257,856,700.00	307,911,700.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	257,856,700.00	307,911,700.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,212,760.00	3,050,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,212,760.00	3,050,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	10,696,200.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	10,696,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	288,669,672.60	344,487,018.97
УРСГАЛ ЗАРДАЛ	288,669,672.60	344,487,018.97
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,631,133.60	342,488,824.97
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,786,425.00	210,758,650.45
Үндсэн цалин	129,997,216.00	189,862,979.45
Нэмэгдэл	20,173,600.00	11,049,742.00
Урамшуулал	11,615,609.00	9,845,929.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,488,536.00	26,140,272.00
Тэтгэврийн даатгал	13,028,787.00	17,559,769.00
Тэтгэмжийн даатгал	1,603,800.00	2,146,585.00
ҮОМШӨ-ний даатгал	1,283,041.00	1,716,400.00
Ажилгүйдлийн даатгал	570,002.00	428,866.00
Эрүүл мэндийн даатгал	3,002,906.00	4,288,652.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,239,000.00	8,698,006.00
Гэрэл, цахилгаан	2,839,800.00	3,704,516.00
Түлш, халаалт	6,238,800.00	4,693,490.00
Цэвэр, бохир ус	160,400.00	300,000.00
Хангамж, бараа материалын зардал	13,813,396.88	15,608,111.00
Бичиг хэрэг	477,900.00	1,110,000.00
Тээвэр, шатахуун	11,397,479.88	11,847,251.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,750.00	845,860.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	415,200.00	305,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,067.00	1,500,000.00
Нормативт зардал	23,587,633.78	26,874,723.84
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,225,728.00	16,878,723.84
Хоол, хүнс	6,000,005.78	7,996,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,361,900.00	2,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	7,166,205.00	7,401,750.00



Дорнод аймгийн Баянтүмэн сумын эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Багаж, техник, хэрэгсэл	656,500.00	400,000.00
Урсгал засвар	6,509,705.00	7,001,750.00
Томилолт, зочны зардал	541,000.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	541,000.00	1,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,099,200.00	21,072,147.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,739,200.00	20,824,147.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	34,500.00	2,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	33,909,736.94	24,935,164.68
Бараа үйлчилгээний бусад зардал	5,386,400.00	6,126,400.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,523,336.94	18,808,764.68
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,539.00	1,998,194.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,998,194.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,998,194.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(18,786,952.60)	119,091,921.32
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(102,294,703.28)	119,091,921.32

4.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	264,069,460.00	330,021,290.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	8,363,390.00
Тусламжийн орлого	-	8,363,390.00
Хандив тусламж /дотоод/	-	8,363,390.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	264,069,460.00	321,657,900.00
Улсын төвлөрсөн төсвөөс	257,856,700.00	307,911,700.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	257,856,700.00	307,911,700.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	6,212,760.00	3,050,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,212,760.00	3,050,000.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	10,696,200.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	10,696,200.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	264,069,460.00	330,021,290.00
УРСГАЛ ЗАРДАЛ	264,069,460.00	330,021,290.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,030,921.00	328,023,096.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	161,863,425.00	210,758,650.45
Үндсэн цалин	130,074,216.00	189,862,979.45
Нэмэгдэл	20,173,600.00	11,049,742.00
Урамшуулал	11,615,609.00	9,845,929.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,488,536.00	26,140,272.00
Тэтгэврийн даатгал	12,959,114.00	17,559,769.00
Тэтгэмжийн даатгал	1,372,388.00	2,146,585.00
ҮОМШӨ-ний даатгал	1,385,324.00	1,716,400.00
Ажилгүйдлийн даатгал	523,721.00	428,866.00
Эрүүл мэндийн даатгал	3,247,989.00	4,288,652.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,239,000.00	8,698,006.00
Гэрэл, цахилгаан	2,839,800.00	3,704,516.00
Түлш, халаалт	6,238,800.00	4,693,490.00
Цэвэр, бохир ус	160,400.00	300,000.00
Хангамж, бараа материалын зардал	13,788,022.00	15,608,111.00
Бичиг хэрэг	450,000.00	1,110,000.00
Тээвэр, шатахуун	11,400,000.00	11,847,251.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,750.00	845,860.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	415,200.00	305,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,016,072.00	1,500,000.00
Нормативт зардал	23,587,628.00	23,470,499.55
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,225,728.00	13,474,499.55
Хоол, хүнс	6,000,000.00	7,996,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,361,900.00	2,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	10,597,710.00	15,149,010.00
Багаж, техник, хэрэгсэл	3,615,000.00	8,149,010.00
Урсгал засвар	6,982,710.00	7,000,000.00
Томилолт, зочны зардал	541,000.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	541,000.00	1,000,000.00

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,099,200.00	21,072,147.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,739,200.00	20,824,147.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	34,500.00	2,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,826,400.00	6,126,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	5,826,400.00	6,126,400.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,539.00	1,998,194.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,998,194.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,998,194.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	-58,554,119.22	0.00	119,093,326.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	-58,554,119.22	0.00	119,093,326.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	-58,554,119.22	0.00	119,093,326.11
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	-58,554,119.22	0.00	119,093,326.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	-58,554,119.22	0.00	119,093,326.11
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	119,091,921.32	0.00	119,091,921.32
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,329,046.64	63,318,398.69	60,537,802.10	0.00	238,185,247.43

4.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31 нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	342,754,800.00	324,973,096.00
Урсгал зардал	342,754,800.00	324,973,096.00
Бараа, ажил, үйлчилгээний зардал	342,754,800.00	324,973,096.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,287,200.00	210,758,650.45
Үндсэн цалин	180,055,100.00	189,862,979.45
Нэмэгдэл	22,970,500.00	11,049,742.00
Урамшуулал	15,261,600.00	9,845,929.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,816,000.00	26,140,272.00
Тэтгэврийн даатгал	18,234,400.00	17,559,769.00
Тэтгэмжийн даатгал	2,145,600.00	2,146,585.00
ҮОМШӨ-ний даатгал	1,716,400.00	1,716,400.00
Ажилгүйдлийн даатгал	429,200.00	428,866.00
Эрүүл мэндийн даатгал	4,290,400.00	4,288,652.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,696,200.00	8,698,006.00
Гэрэл, цахилгаан	2,839,800.00	3,704,516.00
Түлш, халаалт	7,556,400.00	4,693,490.00
Цэвэр, бохир ус	300,000.00	300,000.00
Хангамж, бараа материалын зардал	17,188,000.00	15,608,111.00
Бичиг хэрэг	1,000,000.00	1,110,000.00
Тээвэр, шатахуун	12,500,000.00	11,847,251.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,000.00	845,860.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	305,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,500,000.00
Нормативт зардал	23,020,500.00	22,420,499.55
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,420,500.00	13,420,499.55
Хоол, хүнс	7,000,000.00	7,000,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,600,000.00	2,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,800,000.00	13,149,010.00
Багаж, техник, хэрэгсэл	11,300,000.00	8,149,010.00
Урсгал засвар	6,500,000.00	5,000,000.00
Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,000,000.00
Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,820,500.00	21,072,147.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,540,000.00	20,824,147.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	34,500.00	2,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,126,400.00	6,126,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	6,126,400.00	6,126,400.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	24,146,900.00	8,363,390.00
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	24,146,900.00	8,363,390.00
Хандив тусламж /дотоод/	24,146,900.00	8,363,390.00